

Батлав: МУИС-ИЙН ХУУЛЬ ЗҮЙН  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ



ПРОФ. Ж.ЭРДЭНЭБУЛГАН

## МУИС - ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛИЙН “ОЮУТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ – 2019” УДИРДАМЖ

2019.04.03

УЛААНБААТАР ХОТ

### Зорилго:

МУИС - Хууль зүйн сургуулийн “Оюутны эрдэм шинжилгээний бага хурал - 2019” (ОЭШБХ-2019) нь оюутны чөлөөтэй сэтгэх, асуудалд шүүмжлэлтэй хандах, хууль, эрх зүйг бүтээлчээр судлах эрмэлзлийг хөгжүүлэх, эрх зүйн сэтгэлгээний логик, шинжлэх ухаанч судалгааны арга зүйг эзэмшүүлэх, хуулийн оюутны эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг бэхжүүлэх, хөхиүлэн дэмжих зорилготой бөгөөд үр дүн нь ирээдүйн хуульчдын оюун санаа, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд тогтвортой хөрөнгө оруулалт хийхэд чиглэнэ.

### Хамрах хүрээ:

МУИС - Хууль зүйн сургуулийн Бакалаврын түвшний оюутнууд

### “ОЭШБХ – 2019”-ын сэдэв:

“Нийтийн ба хувийн эрх зүйн тулгамдсан асуудал”

### Шагнал:

- Тэргүүн байр /1/ өргөмжлөл, 500.000 төгрөг, “Эрх зүй” сэтгүүлд нийтлүүлэх эрх;
- Дэд байр /1/ өргөмжлөл, 400.000 төгрөг, “Эрх зүй” сэтгүүлд нийтлүүлэх эрх;
- Гутгаар байр /1/ өргөмжлөл, 300.000 төгрөг, “Эрх зүй” сэтгүүлд нийтлүүлэх эрх;
- Шилдэг шүүмжлэгч /1/ өргөмжлөл, 100.000 төгрөг.

### Оюутны эрдэм шинжилгээний бага хурлын журам:

1. Шүүгч, илтгэгч, шүүмжлэгч болон бусад хүмүүс энэхүү журмыг чанд баримтална.
2. ОЭШБХ-2019-д ирүүлсэн илтгэл нь нэг буюу түүнээс дээш илтгэгчтэй байж болно.
3. ОЭШБХ-2019-д оролцож байгаа үндсэн илтгэгч, шүүмжлэгч нь МУИС - Хууль зүйн сургуулийн бакалаврын түвшний өдөр болон оройн ангийн оюутан байна.
4. ОЭШБХ-2019 нь хоёр үе шаттайгаар зохион байгуулагдана.

- I шат нь “Нийтийн ба хувийн эрх зүйн тулгамдсан асуудал” сэдвийн хүрээнд хураалгасан бүх илтгэлийг шүүгч нар бичгээр шалган, хамгийн сайн гэж үнэлсэн 8 илтгэлийг тодруулна;

- II шат нь хамгийн сайн гэж шалгарсан нийт 8 илтгэлийг хэлэлцүүлж, шилдэг илтгэлүүдийг шалгаруулна.

а) Шүүгч хараат бус байж, шүүгчийн ёс зүйг чандлан баримталж, гагцхүү ОЭШБХ-2019-ын журамд захирагдана. Шүүгч тусгайлан бэлтгэсэн хүснэгтэд заасан шалгуур тус бүрт оноо тавин дүгнэх бөгөөд дээд оноо нь 100 байна.

b) Хугацаа хожимдсон илтгэл хүлээн авахгүй бөгөөд хураалгасан илтгэл, шүүмжийн эх хувийг буцаан олгохгүй. Хураалгасан илтгэл, шүүмжийг засварлахыг хориглоно. Хэрвээ оролцогч энэ заалтыг зөрчвөл хуралд оролцох эрхээ алдана.

c) Хураалгах илтгэл нь урьд нь хэвлэгдээгүй буюу хэлэлцэгдээгүй байх ба энэ заалтыг зөрчиж хуралдаанд хэлэлцэгдсэн илтгэл шагналт байранд шалгарахгүй болно.

d) Шүүмжлэгч шүүмжээ тогтоосон хугацаанд хураалгана. Шүүмжээ бичгээр өгөөгүй тохиолдолд тухайн шүүмж шагналт байранд шалгарахгүй болно.

e) ОЭШБХ-2019-ын хуралдаанд дараах хугацааг чанд баримтална.

- Илтгэл /10 минут/
- Шүүмж /5 минут/
- Мэтгэлцээн /10 минут/

#### **Хугацаа:**

- Илтгэлийг 2019.05.03-ний баасан гарагийн 18:00 цаг хүртэл МУИС-ийн Хууль зүйн сургуулийн 320 тоотод хүлээн авна. Илтгэлийг бичмэл эхээр хураалгахаас гадна дээрх хугацааны дотор [t@num.edu.mn](mailto:t@num.edu.mn) цахим хаягаар илгээсэн байна.

- Шүүмж тавих хүсэлтэй оюутнуудыг 2019.05.01-ны өдөр бүртгэж, шүүмжлэх илтгэлийг нь сонгуулж, шүүмж хураалгах хугацааг товлон. Шүүмжлэгч шүүмжийнхээ нэг хувийг бичгээр, тогтоосон хугацаанд хураалгана.

- ОЭШБХ-2019-ын II шат 2019.05.10-ны баасан гарагийн 10:00 цагт МУИС-ийн Хууль зүйн сургуулийн 331 тоот (өргөтгөл)-д эхэлнэ.

#### **Илтгэл хүлээн авах шалгуур:**

- Тогтоосон хугацаанд хүлээлгэн өгсөн байх (хугацаа хэтэрсэн илтгэлийг хурааж авахгүй болно);

- Урьд өмнө хэвлэгдээгүй буюу хэлэлцүүлээгүй байна;

- Илтгэлийн нүүр (илтгэлийн нүүр тусдаа байна);

1. Илтгэлийн сэдэв;
2. Удирдагч багшийн нэр;
3. Илтгэгчийн овог болон өөрийн нэр;
4. Сургууль, анги;

- Илтгэлийн хэлбэр:

1. Цаасны хэмжээ А4;
2. Мөр хоорондын зай 1.15;
3. Үсгийн фонт Times new roman;
4. Үсгийн өндөр 12;
5. Хуудасны тоо 7-оос доошгүй /илтгэлийн нүүр болон хавсралтыг оролцуулахгүй/.
6. Бичвэрийг хэвлэмэл хуудсанд байрлуулахдаа цаасны зүүн захаас 30 мм, баруун захаас 15 мм, дээд захаас 20 мм, доод захаас 20 мм хэмжээтэй байхаар тохируулна.

- Илтгэлийн нүүр болон бусад хуудсыг үдээгүй байх ба нүүрнээс бусад хуудсанд удирдагч багшийн болон өөрийн овог, нэр, түүнчлэн сургууль, ангиа бичээгүй байна.

**Шилдэг илтгэлийг шалгаруулах шалгуур:**

- Илтгэгчийг дүгнэх шалгуур (Зөвхөн II шатанд хамаарна):

1. Илтгэх чадвар;
2. Мэтгэлцэх чадвар;
3. Сэдвийг өөрийн болгож чадсан байдал;
4. Цаг ашиглалт;
5. Хурдан, оновчтой сэтгэх чадвар.

- Илтгэлийг дүгнэх шалгуур (I болон II шатанд хамаарна):

1. Шинэ санаа, оновчтой шийдэл, сэдвийн ач холбогдол;
2. Логик дэс дараалал;
3. Шинжлэх ухааны үндэслэлтэй хандаж буй байдал;
4. Асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай мэдээллийн хүрээг зөв тодорхойлсон эсэх;
5. Цуглуулсан мэдээлэл нь үнэн зөв эсэх, мэдээллийн эх сурвалжийг зөв тодорхойлсон эсэх;
6. Судалгааны аргыг оновчтой хэрэглэсэн байдал;
7. Тавьсан зорилгодоо хүрсэн эсэх.

**Дэлгэрэнгүй мэдээллийг:**

- 99757248, 96442215

- <https://www.facebook.com/LawSchoolNUM/?fref=ts> фэйсбүүк хаягаар тус тус лавлана уу.

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ  
ОЮУТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ "ЭНТИМЕМА" КЛУБ  
МУИС-ИЙН ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛИЙН ОЮУТНЫ ЗӨВЛӨЛ  
ОЮУТНЫ МЭТГЭЛЦЭЭНИЙ "БЕРКЛИ" КЛУБ  
АНГЛИ ХЭЛНИЙ "ENGLISH SPEAKING CLUB"  
АРБИТР ХЭЛЭЛЦЭЭРИЙН "A&N" КЛУБ  
ЗАЛУУ БАГШ НАРЫН КЛУБ